о хоног тутмын хэвлэл
ны 11 дүгээр сарын 11
№42 /663/

# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

онгол Улсын Их
Хурлын тогтоол

1683

Монгол Улсын
рөнхийлөгчийн
зарлиг

1686

Монгол Улсын
Засгийн газрын
тогтоол

1688



## Нөхөн олговрын доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай

## Монголын тулгар төрийн 2220 жилийн ойг тэмдэглэх тухай

## Концессын зүйлийн жагсаалт батлах тухай

# ГАРЧИГ

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

356. Монгол, Хятадын хилийн дэглэмийн тухай Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хоорондын гэрээ соёрхон батлах тухай 1678

357. Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил, үйлчилгээ хувиараа эрхлэгч иргэний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай 1679

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

358. Шүүгчийн болон прокурорын албан тушаалын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай Дугаар 51 1679

359. Авлигатай тэмцэх газрын албан хаагчийн албан тушаалын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай Дугаар 52 1682

360. Нөхөн олговрын доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай Дугаар 53 1683

361. Тэтгэмж, мөнгөн тусламжийн хэмжээг өөрчлөн тогтоох тухай Дугаар 54 1683

362. Тогтоол хүчингүй болсонд тооцох тухай Дугаар 55 1684

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

363. Олон нийтийн оролцоот хөгжил-“Хуримтлалын бүлэг”-ийн үйл ажиллагааг дэмжиж орон даяар өрнүүлэх тухай Дугаар 215 1685

364. Монголын тулгар төрийн 2220 жилийн ойг тэмдэглэх тухай Дугаар 216 1686

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

| | | | |
|---|---|---|---|
| 365. | Концессын зүйлийн жагсаалт батлах тухай | Дугаар 198 | 1688 |
| 366. | Тогтоолд нэмэлт оруулах тухай | Дугаар 203 | 1704 |
| 367. | Хүүхдийн спортын IV их наадам зохион байгуулах тухай | Дугаар 210 | 1704 |
| 368. | 2011 онд зохион байгуулах олон улсын хэмжээний спортын тэмцээний тухай | Дугаар 211 | 1705 |
| 369. | Сумдад мал эмнэлэг, үржлийн нэгж байгуулах тухай | Дугаар 223 | 1706 |
| 370. | Олон улсын Монголч эрдэмтдийн Их хурал хуралдуулах тухай | Дугаар 227 | 1707 |
| 371. | Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай | Дугаар 235 | 1708 |


## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2010 оны 10 дугаар сарын 21-ний өдөр — Улаанбаатар хот

### МОНГОЛ, ХЯТАДЫН ХИЛИЙН ДЭГЛЭМИЙН ТУХАЙ МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР, БҮГД НАЙРАМДАХ ХЯТАД АРД УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР ХООРОНДЫН ГЭРЭЭГ СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** 2010 оны 06 дугаар сарын 01-ний өдөр Улаанбаатар хотноо гарын үсэг зурсан Монгол, Хятадын хилийн дэглэмийн тухай Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хоорондын гэрээг Монгол Улсын Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон батлагсугай.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА** — **Д.ДЭМБЭРЭЛ**

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2010 оны 10 дугаар сарын 21-ний өдөр — Улаанбаатар хот

### ОРЛОГЫГ НЬ ТУХАЙ БҮР ТОДОРХОЙЛОХ БОЛОМЖГҮЙ АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭ ХУВИАРАА ЭРХЛЭГЧ ИРГЭНИЙ ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил, үйлчилгээ хувиараа эрхлэгч иргэний орлогын албан татварын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсгийн хүснэгтэд дор дурдсан агуулгатай 16 дахь заалт нэмсүгэй:

"

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 16 | Бичил уурхай эрхлэгч | | 53000 | 53000 | 53000 |

"

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг 2010 оны 10 дугаар сарын 21-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА — Д.ДЭМБЭРЭЛ**

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2010 оны 10 дугаар сарын 21-ний өдөр — Дугаар 51 — Улаанбаатар хот

### Шүүгчийн болон прокурорын албан тушаалын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай

Төрийн албаны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.5 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Монгол Улсын шүүхийн шүүгчийн албан тушаалын цалингийн хэмжээг 1 дүгээр хавсралтаар, Монгол Улсын прокурорын байгууллагын прокурорын албан тушаалын цалингийн хэмжээг 2 дугаар хавсралтаар тус тус шинэчлэн тогтоож, 2010 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн

дагаж мөрдөхөөр тогтоосугай.

2.Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Шүүгчийн болон прокурорын албан тушаалын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай" Улсын Их Хурлын 2008 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн 08 дугаар тогтоолыг 2010 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН**
**ИХ ХУРЛЫН ДАРГА** **Д.ДЭМБЭРЭЛ**

**Монгол Улсын Их Хурлын 2010 оны 51 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралт**

## МОНГОЛ УЛСЫН ШҮҮХИЙН ШҮҮГЧИЙН АЛБАН ТУШААЛЫН ЦАЛИНГИЙН ХЭМЖЭЭ

| № | Албан тушаал | Албан тушаалын сарын цалингийн хэмжээ (төгрөгөөр) |
|---|---|---|
| 1 | Нийслэлийн шүүхийн Ерөнхий шүүгч | 706789.2 |
| 2 | Нийслэлийн шүүхийн шүүгч | 649490.4 |
| 3 | Аймгийн шүүхийн Ерөнхий шүүгч | 678056.6 |
| 4 | Аймгийн шүүхийн шүүгч | 628609.8 |
| 5 | Дүүргийн шүүхийн Ерөнхий шүүгч | 636460.5 |
| 6 | Дүүргийн шүүхийн шүүгч | 607227.4 |
| 7 | Сум, сум дундын шүүхийн Ерөнхий шүүгч | 636460.5 |
| 8 | Сум, сум дундын шүүхийн шүүгч | 607227.4 |

Монгол Улсын Их Хурлын 2010 оны
51 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралт

## МОНГОЛ УЛСЫН ПРОКУРОРЫН БАЙГУУЛЛАГЫН ПРОКУРОРЫН АЛБАН ТУШААЛЫН ЦАЛИНГИЙН ХЭМЖЭЭ

| № | Албан тушаал | Албан тушаалын сарын цалингийн хэмжээ (төгрөгөөр) |
|---|---|---|
| 1 | Улсын ерөнхий прокурорын газрын туслах прокурор | 697934.9 |
| 2 | Улсын ерөнхий прокурорын газрын хяналтын прокурор | 642140.2 |
| 3 | Нийслэлийн прокурор | 694761.6 |
| 4 | Нийслэлийн прокурорын орлогч | 645815.3 |
| 5 | Нийслэлийн прокурорын газрын туслах прокурор | 598874.9 |
| 6 | Нийслэлийн прокурорын газрын хяналтын прокурор | 588350.1 |
| 7 | Аймаг, тээврийн прокурор | 666529.5 |
| 8 | Аймаг, тээврийн прокурорын орлогч | 618586.8 |
| 9 | Аймаг, тээврийн прокурорын газрын туслах прокурор | 598874.9 |
| 10 | Аймаг, тээврийн прокурорын газрын хяналтын прокурор | 588350.1 |
| 11 | Дүүргийн прокурор | 610902.5 |
| 12 | Дүүргийн прокурорын орлогч | 598874.9 |
| 13 | Дүүргийн прокурорын газрын туслах прокурор | 588350.1 |
| 14 | Дүүргийн прокурорын газрын хяналтын прокурор | 582670.4 |
| 15 | Сум, сум дундын ахлах прокурор | 610902.5 |
| 16 | Сум, сум дундын прокурорын газрын хяналтын прокурор | 582670.4 |

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2010 оны 10 дугаар сарын 21-ний өдөр | Дугаар 52 | Улаанбаатар хот

**Авлигатай тэмцэх газрын албан хаагчийн албан тушаалын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай**

Авлигын эсрэг хуулийн 29 дүгээр зүйлийн 29.6 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Авлигатай тэмцэх газрын албан хаагчийн албан тушаалын цалингийн хэмжээг хавсралтаар шинэчлэн тогтоож, 2010 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөхөөр тогтоосугай.

2.Энэ тогтоол батлагдсантай холбогдуулан "Авлигатай тэмцэх газрын албан хаагчийн албан тушаалын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай" Улсын Их Хурлын 2008 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн 09 дүгээр тогтоолыг 2010 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА** **Д.ДЭМБЭРЭЛ**

**Монгол Улсын Их Хурлын 2010 оны
52 дугаар тогтоолын хавсралт**

### АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗРЫН АЛБАН ХААГЧИЙН АЛБАН ТУШААЛЫН ЦАЛИНГИЙН ХЭМЖЭЭ

| № | Албан тушаал | Албан тушаалын сарын цалин (төгрөгөөр) |
|---|---|---|
| 1 | Авлигатай тэмцэх газрын дарга | 1066694 |
| 2 | Авлигатай тэмцэх газрын дэд дарга | 988185.9 |
| 3 | Хэлтсийн дарга | 944034 |
| 4 | Албаны дарга | 890089.2 |
| 5 | Ахлах ажилтан | 809172 |
| 6 | Ажилтан | 728254.8 |

# МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2010 оны 10 дугаар сарын 21-ний өдөр | Дугаар 53 | Улаанбаатар хот

**Нөхөн олговрын доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай**

Монгол Улсын Их Хурлын 1999 оны 4 дүгээр сарын 22-ны өдрийн 24 дүгээр тогтоолын 1 дэх заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Тэтгэвэр нь түр зогсоогдсон иргэдийн авч байгаа нөхөн олговрын доод хэмжээг сард 105300 /нэг зуун таван мянга гурван зуун/ төгрөг байхаар шинэчлэн тогтоож, 2010 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

2.Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Нөхөн олговрын доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай" Улсын Их Хурлын 2008 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн 11 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА** **Д.ДЭМБЭРЭЛ**

# МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2010 оны 10 дугаар сарын 21-ний өдөр | Дугаар 54 | Улаанбаатар хот

**Тэтгэмж, мөнгөн тусламжийн хэмжээг өөрчлөн тогтоох тухай**

Нийгмийн халамжийн тухай хуулийн $19^1$ дүгээр зүйлийн $19^1$.6 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Эхэд жирэмсний 5 сартайгаас эхлэн 12 сарын хугацаанд сар бүр олгох тэтгэмжийн хэмжээг 26000 /хорин зургаан мянган/ төгрөгөөр, "Эхийн алдар" нэгдүгээр зэргийн одонтой эхэд жилд нэг удаа олгох мөнгөн тусламжийн хэмжээг 200000 /хоёр зуун мянган/ төгрөгөөр, "Эхийн алдар"

хоёрдугаар зэргийн одонтой эхэд жилд нэг удаа олгох мөнгөн тусламжийн хэмжээг 100000 /нэг зуун мянган/ төгрөгөөр тус тус өөрчлөн тогтоож, 2010 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

2.Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Эхийн алдар" одонтой эхэд 2010 онд олгох мөнгөн тусламжийн зөрүүг 2010 оны 4 дүгээр улиралд багтаан олгохыг Монгол Улсын Засгийн газар /С.Батболд/-т даалгасугай.

3.Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Тэтгэмжийн хэмжээг тогтоох тухай" Улсын Их Хурлын 2007 оны 01 дүгээр сарын 04-ний өдрийн 02 дугаар тогтоол, "Мөнгөн тусламжийн хэмжээг тогтоох тухай" Улсын Их Хурлын 2007 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн 21 дүгээр тогтоолыг 2010 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн тус тус хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН**
**ИХ ХУРЛЫН ДАРГА** **Д.ДЭМБЭРЭЛ**

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

| | | |
|---|---|---|
| 2010 оны 10 дугаар сарын 21-ний өдөр | Дугаар 55 | Улаанбаатар хот |

**Тогтоол хүчингүй болсонд тооцох тухай**

Нийгмийн халамжийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1, 34 дүгээр зүйлийн 34.1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1."Нийгмийн халамжийн тэтгэврийн хэмжээг өөрчлөн тогтоох тухай" Улсын Их Хурлын 2008 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн 02 дугаар тогтоол, "Нийгмийн халамжийн нөхцөлт мөнгөн тэтгэмжийн хэмжээг өөрчлөн тогтоох тухай" Улсын Их Хурлын 2008 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн 10 дугаар тогтоолыг 2010 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн тус тус хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН**
**ИХ ХУРЛЫН ДАРГА** **Д.ДЭМБЭРЭЛ**

# МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

| | | |
|---|---|---|
| 2010 оны 10 дугаар сарын 14-ний өдөр | Дугаар 215 | Улаанбаатар хот |

**Олон нийтийн оролцоот хөгжил-
"Хуримтлалын бүлэг"-ийн үйл
ажиллагааг дэмжиж орон
даяар өрнүүлэх тухай**

Монгол Улс суурин соёл иргэншилд шилжиж, хотжих үйл явц эрчимтэй явагдаж байгаа өнөө үед иргэдийн өөрсдийн санал, оролцоон дээр тулгуурлан орчин тойрон, амьдрал ахуйгаа сайжруулах чиглэлээр хүчээ нэгтгэн ажиллаж, үр дүнд хүрч байгаа "Хуримтлалын бүлэг"-ийн үүсгэл санаачилгыг нийт иргэдэд түгээн дэлгэрүүлэх, олон нийтийн үйл хэрэг болгох зорилгоор Монгол Улсын Үндсэн хуулийн 34 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийг тус тус үндэслэн **ЗАРЛИГ БОЛГОХ** нь:

1. Байгаль орчноо зөв зохистой ашиглах, хамгаалах, амьдарч буй орчноо тохижуулах, хамтарч ажиллан амьдрал ахуйгаа дээшлүүлэх зорилгоор "Хуримтлалын бүлэг" байгуулан ажиллах үүсгэл санаачилгыг орон даяар өрнүүлэхийг Монгол Улсын нийт ард иргэдэд уриалсугай.

2. Хамтын хүчний давуу талыг бий болгон амжилттай ажиллаж байгаа "Хуримтлалын бүлэг"-үүдийн санал санаачилгыг дотоод, гадаадын төсөл, хөтөлбөрт хамруулан бодит ажил болгох, бүх талын дэмжлэг туслалцаа үзүүлэхийг Монгол Улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа үйлдвэрийн газар, аж ахуйн нэгж, төрийн болон төрийн бус байгууллагын удирдлагуудад зөвлөсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ** **Ц.ЭЛБЭГДОРЖ**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

| | | |
|---|---|---|
| 2010 оны 10 дугаар сарын 15-ны өдөр | Дугаар 216 | Улаанбаатар хот |

**Монголын тулгар төрийн 2220 жилийн ойг тэмдэглэх тухай**

Манай эриний өмнөх 209 онд Модун шаньюй Төв Азид нутаглах нүүдэлчин аймгуудыг байлдан дагуулж нэгтгэснээр нүүдэлчдийн анхны төр улс болох хүчирхэг Хүннү гүрэнг байгуулсан билээ. Хүннү гүрэн Төв Азийн өргөн уудам нутаг дэвсгэрт үе үеийн монгол угсаатны амьдран буй газар нутгийг эзлэн оршиж байжээ.

Гурван зуу гаруй жил оршин тогтносон тус улс нүүдэлчдийн дунд төрт ёсны их уламжлалыг бий болгосон. Хүннүчүүд улс гүрнээ гурван гарт хуваан, бүгд хорин дөрвөн түмтийн ноён тохоон томилсон бөгөөд аравтын тогтолцоонд үндэслэн цэрэг - засаг захиргааны байгуулал хэрэгжүүлсэн байна. Энэ нь Чингис хааны байгуулсан Их Монгол Улсын үндэс болсон юм.

Монголчуудын өвөг дээдэс бол Хүннү нар болой, бид их Модун хааны түүх, уламжлалыг авч яваа хэмээн Эзэн богд Чингис хаан захиж үлдээсэн байдаг.

Хүн ардынхаа үндэсний ухамсар, эх түүхийн бахархал, тэмүүллийн үзэл санааг төлөвшүүлэх, монгол төрийн үндсийг улам бэхжүүлэх, эртний дэлхий дахины түүхийн үйл явцад, түүний дотор Евразийн олон үндэстний түүхэнд гүнзгий ул мөр үлдээсэн бидний өвөг дээдэс болох Хүннүчүүдийн болон Монголын тулгар төрийн буурал түүх шастир, өв соёлыг судалж сэргээх, батжуулах зорилгоор эрдэмтэн судлаачид, иргэд, байгууллагаас гаргаж буй саналыг дэмжиж Монгол Улсын Үндсэн хуулийн гучиндөрөвдүгээр зүйлийн 1 дэх заалтыг баримтлан ЗАРЛИГ БОЛГОХ нь:

1. Монголын тулгар төрийн 2220 жилийн ойг 2011 онд төр ёсны их баяр болгон ёслон тэмдэглэсүгэй.

2. Монголын тулгар төрийн 2220 жилийн ойг угтаж тусгай хөтөлбөр хэрэгжүүлэх, ойг тэмдэглэх ажлыг удирдан зохион байгуулах Үндэсний хороог байгуулан ажиллахыг Монгол Улсын Засгийн газар (Ерөнхий сайд С. Батболд) – т чиглэл болгосугай.

3. Түүхт ойг угтаж хэрэгжүүлэх Тусгай хөтөлбөрийн агуулгад:

а. Түүхийн ой санамжийг бүрдүүлэх, өвлүүлэх, хадгалах үүднээс "Дэлхийн нүүдэлчдийн түүх, соёлын төв" (дэргэдээ хүүхдийн "Тэмүүжин" цэнгэлдэх хүрээлэн бүхий) цогцолборыг үе шаттайгаар барьж байгуулах;

б. Монголын тулгар төрийн түүхийг үе улираан судлах, Төв Азийн нүүдэлчдийн соёл иргэншил, Хүнну судлалыг гүнзгийрүүлж олон улсын эрдэм шинжилгээний хурал, семинар, судалгаа шинжилгээний экспедиц зохион байгуулах;

в. Монгол төрийн үүсэл, ёс, ёслол, хүндэтгэл уламжлалыг эрт эртнээс өдгөө хүртэл нэгтгэн судлах, ном бүтээх, шинжлэх ухаан, урлаг, уран сайхны бусад олон төрлийн бүтээл туурвих санаачлагыг дэмжих;

г. Ойг Төв Азийн улс түмнүүд болон гадаад орнуудад өргөн сурталчлах, ЮНЕСКО-гоор дэмжүүлэх зэрэг арга хэмжээг багтаан оруулах нь зүйтэй гэж үзсүгэй.

4. Шинэ зууны хоёр дахь арван жилийн эхэнд тохиож буй их ойг угтаж улс үндэстнийхээ өнгөрсөн, одоо, ирээдүйг эрхэмлэх сэтгэлээр түүх соёлоо бадраан мандуулах идэвх, бүтээлч санаачлагаа дайчлахыг үндэс угсаагаа шүтэгч монгол хүн бүрт хандан уриалсугай.

| | |
|---|---|
| **МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ** | **МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД** |
| **Ц.ЭЛБЭГДОРЖ** | **С.БАТБОЛД** |

# МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2010 оны 7 дугаар сарын 21-ний өдөр | Дугаар 198 | Улаанбаатар хот

**Концессын зүйлийн жагсаалт батлах тухай**

Концессын тухай хуулийн 6.1.1, 10.1-ийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Төрийн өмчийн концессын зүйлийн жагсаалт"-ыг хавсралт ёсоор батлагсугай.

2. Жагсаалтад тусгагдсан төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, жил бүрийн улсын төсөвт тусгах, олон улсын банк, санхүүгийн байгууллагын төсөлд хамруулах, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг татан оролцуулан санхүүжүүлэх арга хэмжээ авахыг Сангийн сайд С.Баярцогт, Төрийн өмчийн хороо (Д.Сугар), Үндэсний хөгжил, шинэтгэлийн хороо (Ч.Хашчулуун)-нд тус тус даалгасугай.

3. Жагсаалтад тусгагдсан төсөл, арга хэмжээний концессын гэрээг тухай бүр Засгийн газрын хуралдаанаар оруулж батлуулахыг Төрийн өмчийн хороо (Д.Сугар)-нд үүрэг болгосугай.

4. Жагсаалтын биелэлтийн явц, хүрсэн үр дүн, хэрэгжилтийн талаар жил бүрийн 2 дугаар сарын 15-ны дотор Засгийн газарт танилцуулж байхыг Төрийн өмчийн хороо (Д.Сугар)-нд үүрэг болгосугай.

5. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Боомтуудын ерөнхий төлөвлөгөө, концессын зүйлийн жагсаалт батлах тухай" Засгийн газрын 2010 оны 4 дүгээр сарын 28-ны өдрийн 102 дугаар тогтоолын 2, 3 дугаар зүйл, "2010 онд хувьчлах, өөрчлөн байгуулах төрийн өмчит хуулийн этгээдийн жагсаалт батлах тухай" Засгийн газрын 2010 оны 4 дүгээр сарын 7-ны өдрийн 86 дугаар тогтоолын хавсралтын 2, 3 дахь заалтыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД** — **С.БАТБОЛД**

**МОНГОЛ УЛСЫН САЙД, ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА** — **Ч.ХҮРЭЛБААТАР**

Засгийн газрын 2010 оны 198 дугаар
тогтоолын хавсралт

## ТӨРИЙН ӨМЧИЙН КОНЦЕССЫН ЗҮЙЛИЙН ЖАГСААЛТ

| № | Концессын зүйлийн нэр | Концессын зүйлийн тодорхойлолт | Концессын төрөл | Гүйцэтгэх ажил, үзүүлэх үйлчилгээ | Төсвийн хөрөнгөөр санхүүгийн дэмжлэг үзүүлэх, баталгаа гаргах эсэх | Уралдаант шалгаруулалт явуулах, шууд гэрээ байгуулах эсэх |
|---|---|---|---|---|---|---|
| | | | Нэг. Орон сууц, барилга байгууламжийн төслүүд | | | |
| 1 | Орон сууцны XIY хороолол төсөл | Гэр хорооллыг орон сууцны хороолол болгон хөгжүүлэх | Барих-өмчлөх-ашиглах | Орон сууцны хорооллыг эмнэлэг, сургууль, цэцэрлэг, үйлчилгээний төв, спорт цогцолбор, ногоон байгууламжийн хамт барих | Шаардлагагүй | Уралдаант шалгаруулалт явуулах |
| 2 | Орон сууцны XIY хорооллын дэд бүтэц | Орон сууцны хорооллын дэд бүтэц барих | Зураг төсөл боловсруулах-барих-санхүүжүүлэх-шилжүүлэх | Цахилгаан, дулаан, усан хангамж, зам зэрэг инженерийн дэд бүтцийн зураг төсөл боловсруулах, барих, санхүүжүүлэх, шилжүүлэх | Судлан шийдвэрлэх | Уралдаант шалгаруулалт явуулах |
| 3 | "Зүүн сэлбэ" хороолол төсөл | Орон сууцны хороолол болгон хөгжүүлэх | Барих-өмчлөх-ашиглах | Орон сууцны хорооллыг эмнэлэг, сургууль, цэцэрлэг, үйлчилгээний төв, спорт цогцолбор, ногоон байгууламжийн хамт барих | Шаардлагагүй | Уралдаант шалгаруулалт явуулах |
| 4 | "Зүүн сэлбэ" хорооллын дэд бүтэц | Орон сууцны хорооллын дэд бүтэц барих | Зураг төсөл боловсруулах-барих-санхүүжүүлэх-шилжүүлэх | Цахилгаан, дулаан, усан хангамж, зам зэрэг инженерийн дэд бүтцийн зураг төсөл боловсруулах, барих, санхүүжүүлэх, шилжүүлэх | Судлан шийдвэрлэх | Уралдаант шалгаруулалт явуулах |
| 5 | Орон сууцны YII хороолол төсөл | Гэр хорооллыг орон сууцны хороолол болгон хөгжүүлэх | Барих-өмчлөх-ашиглах | Орон сууцны хорооллыг эмнэлэг, сургууль, цэцэрлэг, үйлчилгээний төв, спорт цогцолбор, ногоон байгууламжийн хамт барих | Шаардлагагүй | Уралдаант шалгаруулалт явуулах |
| 6 | Орон сууцны YII хорооллын дэд бүтэц | Орон сууцны хорооллын дэд бүтэц барих | Зураг төсөл боловсруулах-барих-санхүүжүүлэх-шилжүүлэх | Цахилгаан, дулаан, усан хангамж, зам зэрэг инженерийн дэд бүтцийн зураг төсөл боловсруулах, барих, санхүүжүүлэх, шилжүүлэх | Судлан шийдвэрлэх | Уралдаант шалгаруулалт явуулах |
| 7 | МҮОНРТ орчмын хороолол төсөл | Гэр хорооллыг орон сууцны хороолол болгон хөгжүүлэх | Барих-өмчлөх-ашиглах | Орон сууцны хорооллыг эмнэлэг, сургууль, цэцэрлэг, үйлчилгээний төв, спорт цогцолбор, ногоон байгууламжийн хамт барих | Шаардлагагүй | Уралдаант шалгаруулалт явуулах |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 8 | МҮОНРТ орчмын хорооллын дэд бүтэц | Орон сууцны хорооллын дэд бүтэц барих | Зураг төсөл боловсруулах-барих-санхүүжүүлэх-шилжүүлэх | Цахилгаан, дулаан, усан хангамж, зам зэрэг инженерийн дэд бүтцийн зураг төсөл боловсруулах, барих, санхүүжүүлэх, шилжүүлэх | Судлан шийдвэрлэх | Уралдаант шалгаруулалт явуулах |
| 9 | "Гандантэгчинлэн хүрээ хийд" хороолол төсөл | Гэр хорооллыг орон сууцны хороолол болгон хөгжүүлэх | Барих-өмчлөх-ашиглах | Орон сууцны хорооллыг эмнэлэг, сургууль, цэцэрлэг, үйлчилгээний төв, спорт цогцолбор, ногоон байгууламжийн хамт барих | Шаардлагагүй | Уралдаант шалгаруулалт явуулах |
| 10 | "Гандантэгчинлэн хүрээ хийд" хорооллын дэд бүтэц | Орон сууцны хорооллын дэд бүтэц барих | Зураг төсөл боловсруулах-барих-санхүүжүүлэх-шилжүүлэх | Цахилгаан, дулаан, усан хангамж, зам зэрэг инженерийн дэд бүтцийн зураг төсөл боловсруулах, барих, санхүүжүүлэх, шилжүүлэх | Судлан шийдвэрлэх | Уралдаант шалгаруулалт явуулах |
| 11 | "Дэнжийн мянга" хорооллын төсөл | Гэр хорооллыг орон сууцны хороолол болгон хөгжүүлэх | Барих-өмчлөх-ашиглах | Орон сууцны хорооллыг эмнэлэг, сургууль, цэцэрлэг, үйлчилгээний төв, спорт цогцолбор, ногоон байгууламжийн хамт барих | Шаардлагагүй | Уралдаант шалгаруулалт явуулах |
| 12 | "Дэнжийн мянга" хорооллын дэд бүтэц | Орон сууцны хорооллын дэд бүтэц барих | Зураг төсөл боловсруулах-барих-санхүүжүүлэх-шилжүүлэх | Цахилгаан, дулаан, усан хангамж, зам зэрэг инженерийн дэд бүтцийн зураг төсөл боловсруулах, барих, санхүүжүүлэх, шилжүүлэх | Судлан шийдвэрлэх | Уралдаант шалгаруулалт явуулах |
| 13 | СХД-ийн 6 дугаар хороо орчмын хороолол төсөл | Гэр хорооллыг орон сууцны хороолол болгон хөгжүүлэх | Барих-өмчлөх-ашиглах | Орон сууцны хорооллыг эмнэлэг, сургууль, цэцэрлэг, үйлчилгээний төв, спорт цогцолбор, ногоон байгууламжийн хамт барих | Шаардлагагүй | Уралдаант шалгаруулалт явуулах |
| 14 | СХД-ийн 6 дугаар хороо орчмын хорооллын дэд бүтэц | Орон сууцны хорооллын дэд бүтэц барих | Зураг төсөл боловсруулах-барих-санхүүжүүлэх-шилжүүлэх | Цахилгаан, дулаан, усан хангамж, зам зэрэг инженерийн дэд бүтцийн зураг төсөл боловсруулах, барих, санхүүжүүлэх, шилжүүлэх | Судлан шийдвэрлэх | Уралдаант шалгаруулалт явуулах |
| 15 | "Бүянт-Ухаа" цогцолбор хорооллын дэд бүтэц | Орон сууцны хорооллын дэд бүтэц барих | Зураг төсөл боловсруулах-барих-санхүүжүүлэх-шилжүүлэх | Цахилгаан, дулаан, усан хангамж, зам зэрэг инженерийн дэд бүтцийн зураг төсөл боловсруулах, барих, санхүүжүүлэх, шилжүүлэх | Судлан шийдвэрлэх | Уралдаант шалгаруулалт явуулах |
| 16 | "Баянголын ам" цогцолбор хорооллын дэд бүтэц | Орон сууцны хорооллын дэд бүтэц барих | Зураг төсөл боловсруулах-барих-санхүүжүүлэх-шилжүүлэх | Цахилгаан, дулаан, усан хангамж, зам зэрэг инженерийн дэд бүтцийн зураг төсөл боловсруулах, барих, санхүүжүүлэх, шилжүүлэх | Судлан шийдвэрлэх | Уралдаант шалгаруулалт явуулах |
| 17 | "Ургах наран" хорооллын дэд бүтэц | Орон сууцны хорооллын дэд бүтэц барих | Зураг төсөл боловсруулах-барих-санхүүжүүлэх-шилжүүлэх | Цахилгаан, дулаан, усан хангамж, зам зэрэг инженерийн дэд бүтцийн зураг төсөл боловсруулах, барих, санхүүжүүлэх, шилжүүлэх | Судлан шийдвэрлэх | Уралдаант шалгаруулалт явуулах |
| 18 | "Шинэ Яармаг" цогцолбор хорооллын дэд бүтэц | Орон сууцны хорооллын дэд бүтэц барих | Зураг төсөл боловсруулах-барих-санхүүжүүлэх-шилжүүлэх | Цахилгаан, дулаан, усан хангамж, зам зэрэг инженерийн дэд бүтцийн зураг төсөл боловсруулах, барих, санхүүжүүлэх, шилжүүлэх | Судлан шийдвэрлэх | Уралдаант шалгаруулалт явуулах |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 19 | "Ирээдүй" цогцолбор хорооллын дэд бүтэц | Орон сууцны хорооллын дэд бүтэц барих | Зураг төсөл боловсруулах-барих-санхүүжүүлэх-шилжүүлэх | Цахилгаан, дулаан, усан хангамж, зам зэрэг инженерийн дэд бүтцийн зураг төсөл боловсруулах, барих, санхүүжүүлэх, шилжүүлэх | Судлан шийдвэрлэх | Уралдаант шалгаруулалт явуулах |
| 20 | "Дөрвөн улирлын цэцэрлэг" цогцолбор хорооллын дэд бүтэц | Орон сууцны хорооллын дэд бүтэц барих | Зураг төсөл боловсруулах-барих-санхүүжүүлэх-шилжүүлэх | Цахилгаан, дулаан, усан хангамж, зам зэрэг инженерийн дэд бүтцийн зураг төсөл боловсруулах, барих, санхүүжүүлэх, шилжүүлэх | Судлан шийдвэрлэх | Уралдаант шалгаруулалт явуулах |
| 21 | Нийслэлийн зарим дүүргийн орон сууцны барилгыг буулган шинээр орон сууц барих төсөл | Улаанбаатар хотын зургаан дүүрэгт байрлах, бат бэхийн чанар хангалтгүй, газар хөдлөлтөд тэсвэрлэлтгүй зарим барилга байгууламжийг буулгаж, орон сууц барих ажил | Барих-эзэмших-ашиглах | Орон сууцны хорооллыг эмнэлэг, сургууль, цэцэрлэг, үйлчилгээний төв, спорт цогцолбор, ногоон байгууламжийн хамт барих | Шаардлагагүй | Уралдаант шалгаруулалт явуулах |
| 22 | "Голден парк" цогцолбор хорооллын дэд бүтэц | Орон сууцны хорооллын дэд бүтэц барих | Зураг төсөл боловсруулах-барих-санхүүжүүлэх-шилжүүлэх | Цахилгаан, дулаан, усан хангамж, зам зэрэг инженерийн дэд бүтцийн зураг төсөл боловсруулах, барих, санхүүжүүлэх, шилжүүлэх | Судлан шийдвэрлэх | Уралдаант шалгаруулалт явуулах |
| 23 | "Эрин" цогцолбор хорооллын дэд бүтэц | Орон сууцны хорооллын дэд бүтэц барих | Зураг төсөл боловсруулах-барих-санхүүжүүлэх-шилжүүлэх | Цахилгаан, дулаан, усан хангамж, зам зэрэг инженерийн дэд бүтцийн зураг төсөл боловсруулах, барих, санхүүжүүлэх, шилжүүлэх | Судлан шийдвэрлэх | Уралдаант шалгаруулалт явуулах |
| 24 | Орон сууцны XIX хороолол төсөл | Орон сууцны хорооллыг шинэчлэн хөгжүүлэх | Барих-эзэмших-ашиглах | Орон сууцны хорооллын бат бэхийн чанар хангалтгүй, газар хөдлөлтөд тэсвэрлэлтгүй зарим барилга байгууламжийг буулгаж, нэмж эмнэлэг, сургууль, цэцэрлэг, үйлчилгээний төв, спорт цогцолбор, ногоон байгууламжийн хамт барих | Шаардлагагүй | Уралдаант шалгаруулалт явуулах |
| 25 | Орон сууцны XIX хорооллын инженерийн дэд бүтэц | Орон сууцны хорооллын дэд бүтэц барих | Зураг төсөл боловсруулах-барих-санхүүжүүлэх-шилжүүлэх | Цахилгаан, дулаан, усан хангамж, зам зэрэг инженерийн дэд бүтцийн зураг төсөл боловсруулах, барих, санхүүжүүлэх, шилжүүлэх | Судлан шийдвэрлэх | Уралдаант шалгаруулалт явуулах |
| 26 | "Зэрмэл" орон сууцны хороолол төсөл | Орон сууцны хорооллыг шинэчлэн хөгжүүлэх | Барих-эзэмших-ашиглах | Орон сууцны хорооллыг эмнэлэг, сургууль, цэцэрлэг, үйлчилгээний төв, спорт цогцолбор, ногоон байгууламжийн хамт барих | Шаардлагагүй | Уралдаант шалгаруулалт явуулах |
| 27 | "Зэрмэл" орон сууцны хорооллын инженерийн дэд бүтэц | Орон сууцны хорооллын дэд бүтэц барих | Зураг төсөл боловсруулах-барих-санхүүжүүлэх-шилжүүлэх | Цахилгаан, дулаан, усан хангамж, зам зэрэг инженерийн дэд бүтцийн зураг төсөл боловсруулах, барих, санхүүжүүлэх, шилжүүлэх | Судлан шийдвэрлэх | Уралдаант шалгаруулалт явуулах |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 28 | "Нарны замын дагуу барих хороолол" төсөл | Орон сууцны хорооллыг цогцоор хөгжүүлэх | Барих-ашиглах | Орон сууцны хорооллыг эмнэлэг, сургууль, цэцэрлэг, үйлчилгээний төв, спорт цогцолбор, ногоон байгууламжийн хамт барих | Шаардлагагүй | Уралдаант шалгаруулалт явуулах |
| 29 | Нарны зам дагуу барих хорооллын инженерийн дэд бүтэц | Орон сууцны хорооллын дэд бүтэц барих | Зураг төсөл боловсруулах-барих-санхүүжүүлэх-шилжүүлэх | Цахилгаан, дулаан, усан хангамж, зам зэрэг инженерийн дэд бүтцийн зураг төсөл боловсруулах, барих, санхүүжүүлэх, шилжүүлэх | Судлан шийдвэрлэх | Уралдаант шалгаруулалт явуулах |
| 30 | Дунд гол орчмын хороолол төсөл | Орон сууцны хорооллыг цогцоор хөгжүүлэх | Барих-ашиглах | Орон сууцны хорооллыг эмнэлэг, сургууль, цэцэрлэг, үйлчилгээний төв, спорт цогцолбор, ногоон байгууламжийн хамт барих | Шаардлагагүй | Уралдаант шалгаруулалт явуулах |
| 31 | Дунд гол орчмын хорооллын инженерийн дэд бүтэц | Орон сууцны хорооллын дэд бүтэц барих | Зураг төсөл боловсруулах-барих-санхүүжүүлэх-шилжүүлэх | Цахилгаан, дулаан, усан хангамж, зам зэрэг инженерийн дэд бүтцийн зураг төсөл боловсруулах, барих, санхүүжүүлэх, шилжүүлэх | Судлан шийдвэрлэх | Уралдаант шалгаруулалт явуулах |
| 32 | "Түрээсийн орон сууц" төсөл | Бага, дунд орлоготой иргэдэд зориулсан орон сууц барих | Барих-ашиглах | Орон сууцыг эмнэлэг, сургууль, цэцэрлэг, үйлчилгээний төв, спорт цогцолбор, ногоон байгууламжийн хамт барих | Шаардлагагүй | Уралдаант шалгаруулалт явуулах |
| 33 | Түрээсийн орон сууцны инженерийн дэд бүтэц | Орон сууцны хорооллын дэд бүтэц барих | Зураг төсөл боловсруулах-барих-санхүүжүүлэх-шилжүүлэх | Цахилгаан, дулаан, усан хангамж, зам зэрэг инженерийн дэд бүтцийн зураг төсөл боловсруулах, барих, санхүүжүүлэх, шилжүүлэх | Судлан шийдвэрлэх | Уралдаант шалгаруулалт явуулах |
| 34 | Багануур дүүрэгт орон сууцны хороолол барих төсөл | Орон сууцны цогцолбор хороолол барих | Барих-ашиглах | Орон сууцны хорооллыг эмнэлэг, сургууль, цэцэрлэг, үйлчилгээний болон мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төв, спорт цогцолбор, ногоон байгууламжийн хамт барих | Шаардлагагүй | Уралдаант шалгаруулалт явуулах |
| 35 | Багануур дүүргийн орон сууцны хорооллын инженерийн дэд бүтэц | Орон сууцны хорооллын дэд бүтэц барих | Зураг төсөл боловсруулах-барих-санхүүжүүлэх-шилжүүлэх | Цахилгаан, дулаан, усан хангамж, зам зэрэг инженерийн дэд бүтцийн зураг төсөл боловсруулах, барих, санхүүжүүлэх, шилжүүлэх | Судлан шийдвэрлэх | Уралдаант шалгаруулалт явуулах |
| 36 | Багахангай дүүрэгт орон сууцны хороолол барих төсөл | Орон сууцны цогцолбор хороолол барих | Барих-ашиглах | Орон сууцны хорооллыг эмнэлэг, сургууль, цэцэрлэг, үйлчилгээний болон мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төв, спорт цогцолбор, ногоон байгууламжийн хамт барих | Шаардлагагүй | Уралдаант шалгаруулалт явуулах |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 37 | Багахангай дүүргийн орон сууцны хорооллын инженерийн дэд бүтэц | Орон сууцны хорооллын дэд бүтэц барих | Зураг төсөл боловсруулах-барих-санхүүжүүлэх-шилжүүлэх | Цахилгаан, дулаан, усан хангамж, зам зэрэг инженерийн дэд бүтцийн зураг төсөл боловсруулах, барих, санхүүжүүлэх, шилжүүлэх | Судлан шийдвэрлэх | Уралдаант шалгаруулалт явуулах. |
| 38 | Налайх дүүрэгт орон сууцны хороолол барих төсөл | Орон сууцны цогцолбор хороолол барих | Барих-эзэмших-ашиглах | Орон сууцны хорооллыг эмнэлэг, сургууль, цэцэрлэг, үйлчилгээний болон мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төв, спорт цогцолбор, ногоон байгууламжийн хамт барих | Шаардлагагүй | Уралдаант шалгаруулалт явуулах |
| 39 | Налайх дүүргийн орон сууцны хорооллын инженерийн дэд бүтэц | Орон сууцны хорооллын дэд бүтэц барих | Зураг төсөл боловсруулах-барих-санхүүжүүлэх-шилжүүлэх | Цахилгаан, дулаан, усан хангамж, зам зэрэг инженерийн дэд бүтцийн зураг төсөл боловсруулах, барих, санхүүжүүлэх, шилжүүлэх | Судлан шийдвэрлэх | Уралдаант шалгаруулалт явуулах |
| 40 | Аймгийн төвд орон сууц барих дэд төсөл | Орон сууцны цогцолбор хороолол барих | Барих-эзэмших-ашиглах | Орон сууцны хорооллыг эмнэлэг, сургууль, цэцэрлэг, үйлчилгээний болон мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төв, спорт цогцолбор, ногоон байгууламжийн хамт барих | Шаардлагагүй | Уралдаант шалгаруулалт явуулах |
| 41 | Аймгийн төвийн орон сууцны дэд төслийн инженерийн дэд бүтэц | Аймгийн төвийн орон сууцны хорооллын дэд бүтэц барих | Зураг төсөл боловсруулах-барих-санхүүжүүлэх-шилжүүлэх | Цахилгаан, дулаан, усан хангамж, зам зэрэг инженерийн дэд бүтцийн зураг төсөл боловсруулах, барих, санхүүжүүлэх, шилжүүлэх | Судлан шийдвэрлэх | Уралдаант шалгаруулалт явуулах |
| 42 | "Сум дундын загвар төвүүд" төсөл | Нийгмийн дэд бүтцийг цогцолбор байдлаар шийдсэн барилга барих ажил | Зураг төсөл боловсруулах-барих-санхүүжүүлэх-шилжүүлэх | Сум дундын төвийн төлөвлөлтийг шинэчлэх, ерөнхий төлөвлөгөөнд тусгагдсан нийгмийн дэд бүтцийн барилга байгууламж, инженерийн дэд бүтцийг цогцоор байгуулах | Судлан шийдвэрлэх | Уралдаант шалгаруулалт явуулах |
| 43 | "Бургастай боомтын барилга" төсөл | Боомтын барилга байгууламж, инженерийн дэд бүтэц, тоног төхөөрөмжийг шинэчлэх | Шинэчлэн сайжруулах-барих-шилжүүлэх | Барилга байгууламж өргөтгөх, барих, тоног төхөөрөмж шинэчлэх, суурилуулах, дэд бүтэц болон шаардлагатай зам, талбай барих | Судлан шийдвэрлэх | Уралдаант шалгаруулалт явуулах |
| 44 | "Шивээхүрэн боомтын барилга" төсөл | Боомтын барилга байгууламж, инженерийн дэд бүтэц, тоног төхөөрөмжийг шинэчлэх | Шинэчлэн сайжруулах-барих-шилжүүлэх | Барилга байгууламж өргөтгөх, барих, тоног төхөөрөмж шинэчлэх, суурилуулах, дэд бүтэц болон шаардлагатай зам, талбай барих | Судлан шийдвэрлэх | Уралдаант шалгаруулалт явуулах |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 45 | "Булган боомтын барилга" төсөл | Боомтын барилга байгууламж, инженерийн дэд бүтэц, тоног төхөөрөмжийг шинэчлэх | Шинэчлэн сайжруулах-барих-шилжүүлэх | Барилга байгууламж өргөтгөх, барих, тоног төхөөрөмж шинэчлэх, суурилуулах, дэд бүтэц болон шаардлагатай зам, талбайг барих | Судлан шийдвэрлэх | Уралдаант шалгаруулалт явуулах |
| 46 | "Гашуунсухайт боомтын барилга" төсөл | Боомтын барилга байгууламж, инженерийн дэд бүтэц, тоног төхөөрөмжийг шинэчлэх | Шинэчлэн сайжруулах-барих-шилжүүлэх | Барилга байгууламж өргөтгөх, барих, тоног төхөөрөмж шинэчлэх, суурилуулах, дэд бүтэц, шаардлагатай зам, талбайг барих | Судлан шийдвэрлэх | Уралдаант шалгаруулалт явуулах |
| Хоёр. Авто замын төслүүд | | | | | | |
| 47 | Ухаа худаг-Гашуунсухайт чиглэлийн авто зам төсөл | Ашигт малтмалын болон нийтийн хэрэгцээний тээвэрлэлтэд ашиглах 245 км авто зам барих | Барих-ашиглах-шилжүүлэх | Хатуу хучилттай авто замын зураг төсөл боловсруулах, санхүүжүүлэх, барих, ашиглах, шилжүүлэх | Шаардлагагүй | Засгийн газрын 2010 оны 83 дугаар тогтоолын дагуу гэрээ байгуулах |
| 48 | Оюутолгой-Гашуунсухайт чиглэлийн авто зам төсөл | Ашигт малтмалын болон нийтийн хэрэгцээний тээвэрлэлтэд ашиглах 100 км авто зам барих | Барих-ашиглах-шилжүүлэх | Хатуу хучилттай авто замын зураг төсөл боловсруулах, санхүүжүүлэх, барих, ашиглах, шилжүүлэх | Шаардлагагүй | Уралдаант шалгаруулалт явуулах |
| 49 | Тавантолгой-Ханбогд-Ханги чиглэлийн авто зам төсөл | Ашигт малтмалын болон нийтийн хэрэгцээний тээвэрлэлтэд ашиглах 435 км авто зам барих | Барих- ашиглах-шилжүүлэх | Хатуу хучилттай авто замын зураг төсөл боловсруулах, санхүүжүүлэх, барих, ашиглах, шилжүүлэх | Шаардлагагүй | Уралдаант шалгаруулалт явуулах |
| 50 | Нарийнсухайт-Шивээхүрэн чиглэлийн авто зам төсөл | Ашигт малтмалын болон нийтийн хэрэгцээний тээвэрлэлтэд ашиглах 50 км авто зам барих | Барих-ашиглах-шилжүүлэх | Хатуу хучилттай авто замын зураг төсөл боловсруулах, санхүүжүүлэх, барих, ашиглах, шилжүүлэх | Шаардлагагүй | Уралдаант шалгаруулалт явуулах |
| 51 | Ярмагийн гүүрээс Баянзүрхийн товчоо хүртэлх авто зам төсөл | Нийтийн хэрэгцээний тээвэрлэлтийн 17, 6 км авто замын барих | Зураг төсөл боловсруулах-барих-санхүүжүүлэх-шилжүүлэх | Хатуу хучилттай авто замын зураг төсөл боловсруулах, санхүүжүүлэх, барих, шилжүүлэх | Судлан шийдвэрлэх | Уралдаант шалгаруулалт явуулах |
| 52 | Нисэх онгоцны буудал болон нийслэлийг холбосон авто зам төсөл | Улаанбаатар хотыг Хөшигтийн хөндийн нисэх онгоцны буудалтай холбох 53 км хурдны авто зам барих | Барих-ашиглах-шилжүүлэх | Хурдны авто замын зураг төсөл боловсруулах, санхүүжүүлэх, барих, ашиглах, шилжүүлэх | Шаардлагагүй | Уралдаант шалгаруулалт явуулах |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 53 | Алтанбулаг-Улаанбаатар чиглэлийн авто зам төсөл | Алтанбулаг-Улаанбаатар чиглэлийн нийт 367 км хурдны авто зам барих | Барих-ашиглах-шилжүүлэх | Хурдны авто замын зураг төсөл боловсруулах, санхүүжүүлэх, барих, ашиглах, шилжүүлэх | Шаардлагагүй | Уралдаант шалгаруулалт явуулах |
| 54 | Улаанбаатар-Замын-Үүд чиглэлийн авто зам төсөл | Улаанбаатар-Замын-Үүд чиглэлийн нийт 630 км хурдны авто зам барих | Барих-ашиглах-шилжүүлэх | Хурдны авто замын зураг төсөл боловсруулах, санхүүжүүлэх, барих, ашиглах, шилжүүлэх | Шаардлагагүй | Уралдаант шалгаруулалт явуулах |
